



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг  
хүсвэл дараах хаягаар  
харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын дарга  
С.Энхзаяа  
Утас: 261663

Санхүүгийн аудитын менежер  
Ц.Ойдов  
Утас: 260512

Ахлах аудитор Н.Батсайхан  
Утас: 261885

Үндэсний аудитын газар  
Засгийн газрын IY байр  
Бага тойруу -3  
Улаанбаатар 15160  
Монгол улс

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

### Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

#### АГУУЛГА

---

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлтийн үндэслэл

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**Хавсралт 4:** Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Оршил

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны ерөнхий санхүүч болон харьяа байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт тухай бүрд нь танилцуулсан болно.

Аудитад ҮХААС-ын төсвийн багцад хамрагддаг төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч, тусгай сан, төсөл, хөтөлбөр зэрэг нийт 55 газар хамрагдснаас 33 аудитын дүгнэлт гаргаж, 12 төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардалд түүвэр хийсэн ба өгөгдсөн дүгнэлтээс 24 буюу 72 хувьд “зөрчилгүй”, 8 буюу 25 хувьд “Хязгаарлалттай”, Завхан аймгийн ҮХААГ-т “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан”, санал дүгнэлтийг тус тус өгсөн байна.

Менежментийн захидалд ҮХААС-ын төсвийн багцад хамаардаг Яамны үйл ажиллагаа, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Бага оврын тракторын төсөл, Төрийн өмчийн хороо, Мал хамгаалах сангийн санхүүгийн үйл ажиллагаа, сангуудын үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар зөвлөмжүүд өгөгдсөн бөгөөд хэрэгжүүлэх зөвлөмжид ҮХААЯ-ны холбогдох ажилтны саналыг тусгасан болно.

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас биет тестийг хэрэгжүүлээгүй ба үүнээс гарах эрсдлийг аудитын баг хариуцахгүй болно.

Аудитаар хөндөгдсөн асуудлуудыг дор нэгтгэн тайлбарлав.

### **Нэг: Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн бодлого, горим хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн удирдлагын хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд аудитаар дээд түвшний хяналтын асуудлууд хөндөгдсөн бөгөөд үүнийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагын анхааралд хандуулж байна.

- Сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргах аргачлал, зөвлөмжийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйл ажиллагааны онцлогтой уялдуулан зээл, түүний эргэн төлөлт, дамжуулан зээлдүүлэлт, өр авлагаар тусгах, зээлийн эрсдлийн сан бий болгох талаар тусгах

- Урт, богино хугацаат зээлийн эргэн төлөлтийн талаар оновчтой зохион байгуулалт хийх, зээлийн үр дүнгийн талаар тооцоо судалгаа хийж, дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах арга хэмжээ авах

ҮХААЯ-ны дахин хяналтын үр дүнгээс үзэхэд дээр дурьдсан асуудалд анхаарал сул тавьж ажилласан бөгөөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт, санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх үндэслэлийг бүрдүүлээгүй нь ажиглагдсан. Яамны удирдлагын зөвлөлийн хурлаар Сайдын багцын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүнг хэлэлцээгүй байна. Бусад чиглэлээр хяналтыг сайжруулж болох бөгөөд энэ талаар Менежментийн захидалд өгүүлсэн болно.

## **Хоёр: Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

### **Тэргүүлэх ач холбогдол №1**

#### **1. Төсвийг хэтрүүлэн зарцуулсан талаар**

- Тайлант онд батлагдсан төсвийг 40,902.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ тухай тодруулахад СЯ-ны 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 9-1/1454 тоот албан тоотын дагуу "Алтандорнод Монгол" ХХК-иас татварын өрөнд шилжүүлсэн 54,860.8 сая төгрөгийн хөрөнгө, Угтаал салбарыг ашиглалтанд оруулахтай холбоотойгоор гарсан 256.7 сая төгрөгний зардлыг мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгө оруулалтын санхүүжилт, зардлаар бүртгэн тайлагнаснаас төсөв нь хэтэрснээр тайлагнагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", заалтуудыг зөрчсөн ба УСНББОУС-2 стандарттай нийцээгүй байна.

Төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авч бүртгэх, эзэмшүүлэх тухай Төрийн өмчийн хорооны 2013 оны 10 дугаар сарын 10-ны 555 тоот тогтоол нь Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйл, түүнтэй холбогдох журмын шаардлагуудыг хангаагүй шийдвэр тул тухайн эд хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн байгууллагад бүртгэж хөрөнгө оруулалтаар хүлээн зөвшөөрөх боломжгүй тул залруулав.

#### **2. Авлага өглөгийн баталгаажуулалтын талаар**

НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 "Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- ТЭДС-ийн санхүүгийн тайланд буй 32,940.9 сая төгрөгийн өглөг, 68,978.1 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна. Тухайлбал: Гэрээ дүгнэсэн актаар Монгол Улсыг хөгжүүлэх сангийн өр болох 29,550.0 сая төгрөгийн өрийг Сангийн яамтай тооцоо нийлээгүй.

- МХС “Гацуурт” ХХК-иас авах 2,000.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- ТӨХ Сангийн яамтай 2008 онд үүссэн 3,558.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

## **Тэргүүлэх ач холбогдол №2**

### **1. ЗГ-ын тусгай сангийн зарцуулалтын талаар**

• Тайлант онд ТЭДС-гийн хөрөнгөөс 345.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, санхүүгийн зөвлөх үйлчилгээг хувийн аудитын компаниар гүйцэтгүүлж 40.0 сая төгрөг төлж зориулалт бусаар зарцуулсан нь МУ-ын Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1 “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

### **2. Төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулсан талаар**

• Төрийн өмчийн 5235м2 талбай бүхий 5,275.2 сая төгрөгийн үнэтэй барилга байгууламжийг Засгийн газрын шийдвэргүй МҮХАҮТ төрийн бус байгууллагад үнэ төлбөргүй эзэмшүүлж, уг байгууллага дамжуулан түрээслэж төрийн өмчөөр жилд 439.7 сая төгрөгийн орлого олж байгаа нь ТБОНӨТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", 28 дугаар зүйлийн 28.5 "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна..." заалтуудыг зөрчсөн байна.

### **3. Зээлийн тооцоолол болон хугацаа хэтэрсэн зээлийн талаар**

• МХС-гаас 2010 онд олгогдсон 1,098.0 сая төгрөгийн зээлийн хугацааг буруу тооцоолсноос 2013 онд төлөгдөх 472.8 сая төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй, нийт олгосон зээлийн үлдэгдлээс 1,224.8 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн.

• Хятад тракторын зээл төслөөс 2012 онд трактороор 7,977.8 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд 2013 онд гэрээний дагуу төлөгдөх зээлээс 1,131.6 сая төгрөг хугацаандаа төлөгдөөгүй, алданги тооцож авлага үүсгээгүй байна.

### **4. Бага оврийн тракторын зээлийн талаар**

• БНХАУ-ын Засгийн газраас олгосон хөнгөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд 8400 ширхэг трактор нийлүүлэгдснээс одоогийн байдлаар 4339 үлдэгдэлтэй байгаа бөгөөд тайлант онд 387.2 сая төгрөгийн хадгалалтын зардал гарч зээлийн үр ашгийг бууруулж байна.

### **5. Дуусаагүй барилгын талаар**

• ҮХААЯ-ны захиалгаар “Инкон” ХХК-ий барьсан 48 айлын орон сууцанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,068.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд ҮХААЯ-ны аппаратын тайланд дуусаагүй барилга дансанд тусгагдсан байна. Уг орон сууц нь ашиглалтад орсон бөгөөд Улсын комиссын акт 2012 оны 12 сарын 19-нд гарч орон сууцыг эзэмшигчдийн нэр дээр "Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ" гарсан байна.

## **6. Газрыг данс бүртгэлд тусгасан талаар**

- Төрийн өмчийн хорооны 2013.10.10-ны 555 тоот тогтоолоор "Алтандорнод Монгол" ХХК-иас татварын өрөнд хаасан 1,647.9 сая төгрөгийн 517 ширхэг цооногийг ТЭДС-гийн үндсэн хөрөнгийн Газар дансанд бүртгэсэн байгаа нь Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 *"Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн."* заалтыг зөрчсөн тул залруулав.

### **Гурав: Тайлбар мэдүүлгийн захидал**

Үндэсний Аудитын газар аудит хийхдээ Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны удирдлагын зүгээс гаргасан санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлд тулгуурласан бөгөөд аудитын явцад илэрсэн зөрчлийн талаар асуудлын бүртгэлээр холбогдох ажилтнуудад танилцуулж тайлбар, тодруулга авч залруулга хийсэн болно.

### **Дөрөв: Залруулагдаагүй алдаа**

Аудитын стандартын дагуу төрийн аудитын байгууллага аудитын явцад 124,878.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдааг илрүүлсэн бөгөөд санхүүгийн тайланд залруулагдаагүй томоохон алдааг "засаглах удирдлагын" анхааралд хандуулах шаардлагатай.

Аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч залруулга хийхээр зөвшилцсөн тул материаллаг алдаагүй гэж үзлээ.

Яамны харьяа байгууллагууд болон нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулгыг УСНББОУС, түүнд нийцүүлэн боловсруулсан заавар журмын дагуу бэлтгэн толилуулаагүй байна.

### **Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэвэл:**

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцад хамаардаг байгууллагуудад хийсэн аудитаар нийт 124,878.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 4,210.1 сая төгрөгийн алдааг залруулж, 1,227.0 сая төгрөгийн зөрчилд 16 төлбөрийн акт тогтоон, 157.2 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага өгч, 124,200.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар 92 зөвлөмж өгсөн байна.

ҮХААС-ын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар материаллаг байдлыг тооцоолох суурийг тайлант оны нийт хөрөнгийн дүнгээс 2.0 хувиар буюу 4,085.6 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд аудитаар илэрсэн нийт зөрчлөөс санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа 58,185.9 сая төгрөгөөс 55,117.6 сая төгрөгийн алдааг залруулсан тул ҮХААС-ын төсвийн багцын тайланд "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөх үндэс болж байна.

**Тав: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар өгсөн 5 зөвлөмжийн 4 хэрэгжиж, 1 бүрэн хэрэгжээгүй байна.

**Зургаа: Аудитын санал дүгнэлт**

Бид Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД  
Х.БАТТУЛГА ТАНАА

2014.04.25 № 697  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар, тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070478



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

## **Тэргүүлэх ач холбогдол №1:**

### **Асуудал 1**

Батлагдсан төсвийг  
хэтрүүлсэн талаар

### **Асуудал 2**

Авлага, өглөгийн  
баталгаажуулалтын талаар

## **Тэргүүлэх ач холбогдол №2:**

### **Асуудал 1**

ЗГ-ын тусгай сангийн хөрөнгийг зориулалт  
бусаар зарцуулсан талаар

### **Асуудал 2**

Төрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулсан  
талаар

### **Асуудал 3**

Зээлийн тооцоолол болон хугацаа хэтэрсэн  
зээлийн талаар

### **Асуудал 4**

Бага оврийн тракторын зээлийн талаар

### **Асуудал 5**

Дуусаагүй барилгын талаар

### **Асуудал 6**

Газрыг данс бүртгэлд тусгасан талаар



## **МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулж болох зөвлөмжийг өгсөн.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд батлагдсан төсвийг 40,902.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ тухай тодруулахад СЯ-ны 2014 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 9-1/1454 тоот албан тоотын дагуу "Алтандорнод Монгол" ХХК-иас татварын өрөнд шилжүүлсэн 54,860.8 сая төгрөгийн хөрөнгө, Угтаал салбарыг ашиглалтанд оруулахтай холбоотойгоор гарсан 256.7 сая төгрөгний зардлыг мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгө оруулалтын санхүүжилт, зардлаар бүртгэн тайлагнаснаас төсөв нь хэтэрснээр тайлагнагдсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", заалтуудыг зөрчсөн ба УСНББОУС-2 стандарттай нийцээгүй байна.

Төрийн өмчид эд хөрөнгө шилжүүлэн авч бүртгэх, эзэмшүүлэх тухай Төрийн өмчийн хорооны 2013 оны 10 дугаар сарын 10-ны 555 тоот тогтоол нь Татварын ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 1 заалт, түүнтэй холбогдох журмын шаардлагуудыг хангаагүй шийдвэр тул тухайн эд хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн байгууллагад бүртгэж хөрөнгө оруулалтаар хүлээн зөвшөөрөх боломжгүй тул залруулав.

**Эрсдэл**

Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх/Эрх ба үүрэг/

**ҮАГ-ын зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөрчлийг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланг залруулан дахин гаргав.

**ҮАГ-ын ажиглалт**

**ҮАГ-ын зөвлөмж**

НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” заалтыг зөрчсөн байна. Үүнд:

Авлага, өглөгийг баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах;

- ТЭДС-ийн санхүүгийн тайланд буй 32,940.9 сая төгрөгийн өглөг, 68,978.1 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Үүнд: Гэрээ дүгнэсэн актаар Монгол Улсыг хөгжүүлэх сангийн өр болох 29,550.0 сая төгрөгийн өрийг Сангийн яамтай тооцоо нийлээгүй.

- МХС “Гацуурт” ХХК-иас авах 2,000.0 тэрбум төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

- ТӨХ Сангийн яамтай 2008 онд үүссэн 3,558.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

**Эрсдэл**

Авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдэл баталгаажуулаагүй байх /Эрх ба үүрэг/

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвшөөрч байна, хэрэгжүүлж ажиллана.

**ҮАГ-ын ажиглалт**

Тайлант онд ТЭДС-гийн хөрөнгөөс 345.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, санхүүгийн зөвлөх үйлчилгээг хувийн аудитын компаниар гүйцэтгүүлж 40.0 сая төгрөг төлж зориулалт бусаар зарцуулсан нь МУ-ын Засгийн Газрын тусгай сангийн тухай хуулийн 32.1 “Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

**Эрсдэл**

ЗГ-ын тусгай сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байх/Эрх ба үүрэг/

**ҮАГ-ын зөвлөмж**

ЗГ-ын тусгай сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

**ҮАГ-ын ажиглалт**

Төрийн өмчийн 5235м<sup>2</sup> талбай бүхий 5,275.2 сая төгрөгийн үнэтэй барилга байгууламжийг Засгийн газрын шийдвэргүй МҮХАҮТ төрийн бус байгууллагад үнэ төлбөргүй эзэмшүүлж, уг байгууллага дамжуулан түрээслэж төрийн өмчөөр жилд 439.7 сая төгрөгийн орлого олж байгаа нь ТБОНӨТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1 "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", 28 дугаар зүйлийн 28.5 "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна..." заалтуудыг зөрчсөн байна.

**Эрсдэл**

Төрийн өмчийг холбогдох шийдвэргүйгээр ашиглуулах, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэхгүй байх/Эрх ба үүрэг/

**ҮАГ-ын зөвлөмж**

Төрийн өмчийг ашиглуулах тухай шийдвэрийг гаргуулах, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна, хэрэгжүүлж ажиллана.

**ҮАГ-ын ажиглалт**

МХС-гаас 2010 онд олгогдсон 1,098.0 сая төгрөгийн зээлийн хугацааг буруу тооцоолсноос 2013 онд төлөгдөх 472.8 сая төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй, нийт олгосон зээлийн үлдэгдлээс 1,224.8 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн.

Тракторын зээлээр 2012 онд 7,977.8 сая төгрөгийн авлага үүссэн бөгөөд 2013 онд гэрээний дагуу 1,595.6 сая төгрөгийн зээл төлөгдөхөөс 464.0 сая төгрөг төлөгдөж 1,131.6 сая төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

**Эрсдэл**

Зээлийн тооцооллыг буруу хийж данс бүртгэлд тусгах; /үнэн зөв байдал, толилууллага ба илчлэл/

Зээл, зээлийн хүүг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдэл баталгаажуулаагүй байх; /Эрх ба үүрэг/

**ҮАГ-ын зөвлөмж**

Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээ авах;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна, хэрэгжүүлж ажиллана.

**ҮАГ-ын ажиглалт**

БНХАУ-ын Засгийн газраас олгосон хөнгөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд 8400 ширхэг трактор нийлүүлэгдснээс одоогийн байдлаар 4339 үлдэгдэлтэй байгаа бөгөөд тайлант онд 387.2 сая төгрөгийн хадгалалтын зардал гарч зээлийн үр ашгийг бууруулж байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Тракторын хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй тооцоогүйгээс борлуулалт муу, хадгалалтын зардал гарч өртгийг улам нэмэгдүүлж байгаад дүгнэлт хийх;

**Эрсдэл**

Зээлийн үр ашиг, эрсдлийг судлаж тооцоолоогүй байх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна, Хэрэгжүүлж ажиллана.

**ҮАГ-ын ажиглалт**

ҮХААЯ-ны захиалгаар “Инкон” ХХК-ий барьсан 48 айлын орон сууцанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,068.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн бөгөөд тухайн нэгжийн тайланд дуусаагүй барилга дансанд тусгагдсан байна. Уг орон сууц нь ашиглалтад орсон бөгөөд Улсын комиссын акт 2012 оны 12 сарын 19-нд гарч орон сууцыг эзэмшигчдийн нэр дээр "Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ" гарсан байна.

**ҮАГ-ын зөвлөмж**

Ажилчдын орон сууц барихад улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1,068.3 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх;

**Эрсдэл**

Тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үнэн зөв бүртгэгдэхгүй байх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж ажиллана.



**ҮАГ-ын ажиглалт**

Төрийн өмчийн хорооны 2013.10.10-ны 555 тоот тогтоолоор "Алтандорнод Монгол" ХХК-иас татварын өрөнд хаасан 1,647.9 сая төгрөгийн 517 ширхэг цооногийг ТЭДС-гийн үндсэн хөрөнгийн Газар дансанд бүртгэсэн байгаа нь Газрын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн." заалтыг зөрчсөн тул залруулав.

**ҮАГ-ын зөвлөмж**

**Эрсдэл**

Тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх, хөрөнгө үнэн зөв бүртгэгдэхгүй байх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч залруулав.

**АУДИТ ХИЙГДСЭН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	УХААЯ-НЫ ТАЙЛАНГААР		ЗАЛРУУЛСАН	ЗАЛРУУЛСНЫ ДАРААХ	
	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>2,881,844,101.31</b>	<b>7,546,000,511.66</b>		<b>2,881,844,101.31</b>	<b>7,546,000,511.66</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө	14,408,232.74	9,717,812.56		14,408,232.74	9,717,812.56
Төгрөг\ ЖМС	14,408,232.74	9,717,812.56		14,408,232.74	9,717,812.56
Банкинд байгаа бэлэн мөнгө	2,867,435,868.57	7,536,282,699.10		2,867,435,868.57	7,536,282,699.10
Төгрөг	2,867,435,868.57	7,536,282,699.10		2,867,435,868.57	7,536,282,699.10
Төсөвт байгууллагын харилцах	28,000,000.00			28,000,000.00	0.00
Тусгай зориулалтын сангийн харилцах	2,839,435,868.57	6,989,683,458.34		2,839,435,868.57	6,989,683,458.34
Нэмэлт санхүүжилтийн харилцах		546,599,240.76		0.00	546,599,240.76
<b>АВЛАГА</b>	<b>168,472,597,295.11</b>	<b>168,838,151,947.07</b>		<b>168,472,597,295.11</b>	<b>168,838,151,947.07</b>
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,259,081.70	1,035,343.08		1,259,081.70	1,035,343.08
Төлбөртэй үйлчилгээний авлага	73,319,821.37	22,471,803.67		73,319,821.37	22,471,803.67
Татаас, санхүүжилт, (бүтээгдэхүүн нийлүүлэлтийн) авлага	427,735,932.32	250,024,726.13		427,735,932.32	250,024,726.13
Бусад авлага	154,328,689,692.92	152,197,239,717.68		154,328,689,692.92	152,197,239,717.68
Байгууллагаас авах авлага	154,316,646,032.79	152,194,882,054.62		154,316,646,032.79	152,194,882,054.62
Гэрэл цахилгааны авлага		1,150,000.00		0.00	1,150,000.00
Түлш халаалтын авлага		2,742,540.00		0.00	2,742,540.00
Эмийн авлага	34,836.37			34,836.37	0.00
Бусад зардлын тооцооны авлага	154,316,611,196.42	152,190,989,514.62		154,316,611,196.42	152,190,989,514.62
Хувь хүмүүсээс авах авлага	12,043,660.13	2,357,663.06		12,043,660.13	2,357,663.06
Зээлийн авлага	13,641,592,766.80	16,367,380,356.51		13,641,592,766.80	16,367,380,356.51
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	13,641,592,766.80	16,367,380,356.51		13,641,592,766.80	16,367,380,356.51
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	3,744,531,005.00	3,558,223,960.00		3,744,531,005.00	3,558,223,960.00
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	9,897,061,761.80	12,809,156,396.51		9,897,061,761.80	12,809,156,396.51
<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>17,982,630.00</b>	<b>82,010,000.00</b>		<b>17,982,630.00</b>	<b>82,010,000.00</b>
Бусад урьдчилгаа	17,982,630.00	82,010,000.00		17,982,630.00	82,010,000.00
Урьдчилж гарсан зардал	17,982,630.00	82,010,000.00		17,982,630.00	82,010,000.00
Урьдчилж төлсөн зардал	17,982,630.00	82,010,000.00		17,982,630.00	82,010,000.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>81,496,179,116.38</b>	<b>51,806,104,730.20</b>		<b>81,496,179,116.38</b>	<b>51,806,104,730.20</b>
Түүхий эд материал	73,621,830,169.49	47,706,917,145.83		73,621,830,169.49	47,706,917,145.83
Тусгай зориулалттай материал	32,143,848,387.67	32,939,080,023.61		32,143,848,387.67	32,939,080,023.61
Эм боох материал	5,890,879,555.28	2,396,889,212.15		5,890,879,555.28	2,396,889,212.15
Дуусаагүй үйлдвэрлэл	1,160,000,000.00	160,000,000.00		1,160,000,000.00	160,000,000.00
Бэлэн бүтээгдэхүүн	34,427,102,226.54	12,210,947,910.07		34,427,102,226.54	12,210,947,910.07
Хангамжийн материал	1,310,910,744.20	1,688,748,842.75		1,310,910,744.20	1,688,748,842.75
Бичиг хэргийн материал	31,187,797.61	33,724,958.37		31,187,797.61	33,724,958.37
Аж ахуйн материал	510,117,171.05	971,981,345.70		510,117,171.05	971,981,345.70
Сэлбэг хэрэгсэл	27,734,290.72	33,847,298.30		27,734,290.72	33,847,298.30
Түлш, шатах тослох материал	50,402,871.36	113,164,517.59		50,402,871.36	113,164,517.59
Барилгын засварын материал	14,399,657.04	13,604,101.64		14,399,657.04	13,604,101.64
Хүнсний материал	913,700.00	913,700.00		913,700.00	913,700.00

Малын тэжээл	1,048,250.00	207,380.00		1,048,250.00	207,380.00
Баглаа боодол	590,247.40	215,170.99		590,247.40	215,170.99
Бусад бараа материал	674,516,759.02	521,090,370.16		674,516,759.02	521,090,370.16
Мал амьтад	847,151,578.14	1,062,679,878.14		847,151,578.14	1,062,679,878.14
Бусад	5,716,286,624.55	1,347,758,863.48		5,716,286,624.55	1,347,758,863.48
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>252,868,603,142.80</b>	<b>228,272,267,188.93</b>		<b>252,868,603,142.80</b>	<b>228,272,267,188.93</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>43,716,912,622.05</b>	<b>109,229,976,923.57</b>	<b>(54,348,235,239.46)</b>	<b>43,716,912,622.05</b>	<b>54,881,741,684.11</b>
Газар		1,647,896,468.81	(1,647,896,468.81)	0.00	0.00
Биет хөрөнгө	43,206,986,798.05	107,179,991,999.69	(54,860,840,946.00)	43,206,986,798.05	52,319,151,053.69
Барилга, байгууламж, орон сууц	22,725,494,980.98	81,617,047,138.11	(51,106,573,314.43)	22,725,494,980.98	30,510,473,823.68
Барилга, байгууламж орон сууц - Анхны өртөг	31,012,919,083.50	91,074,733,549.26	(51,106,573,314.43)	31,012,919,083.50	39,968,160,234.83
Барилга, байгууламж орон сууц - Хуримтлагдсан элэгдэл	(8,287,424,102.52)	(9,457,686,411.15)	466,122,789.56	(8,287,424,102.52)	(8,991,563,621.59)
Авто-тээврийн хэрэгсэл	4,829,548,343.37	4,896,074,399.57	(9,244,944.39)	4,829,548,343.37	4,886,829,455.18
Авто-тээврийн хэрэгсэл анхны өртөг - Анхны өртөг	7,734,957,468.93	8,450,141,875.44	(9,244,944.39)	7,734,957,468.93	8,440,896,931.05
Авто-тээврийн хэрэгсэл - Хуримтлагдсан элэгдэл	(2,905,409,125.56)	(3,554,067,475.87)	345,102.74	(2,905,409,125.56)	(3,553,722,373.13)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	5,652,253,554.43	11,547,282,561.22	(2,095,696,685.04)	5,652,253,554.43	9,451,585,876.18
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	9,404,995,139.13	16,607,761,508.74	(2,095,696,685.04)	9,404,995,139.13	14,512,064,823.70
Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(3,752,741,584.70)	(5,060,478,947.52)	46,056,001.10	(3,752,741,584.70)	(5,014,422,946.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,244,359,349.78	1,174,945,023.65	(1,429,533.33)	1,244,359,349.78	1,173,515,490.32
Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	2,445,271,171.53	2,508,567,753.90	(1,429,533.33)	2,445,271,171.53	2,507,138,220.57
Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(1,200,911,821.75)	(1,333,622,730.25)	61,813.14	(1,200,911,821.75)	(1,333,560,917.11)
Зам, гүүрийн байгууламж	27,845,100.00	27,845,100.00		27,845,100.00	27,845,100.00
Зам, гүүрийн байгууламж - Анхны өртөг	27,845,100.00	27,845,100.00		27,845,100.00	27,845,100.00
Бусад үндсэн хөрөнгө	2,929,889,605.85	3,157,709,817.14		2,929,889,605.85	3,157,709,817.14
Бусад үндсэн хөрөнгө - Анхны өртөг	4,326,359,873.27	4,919,722,319.03		4,326,359,873.27	4,919,722,319.03
Бусад үндсэн хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(1,396,470,267.42)	(1,762,012,501.89)		(1,396,470,267.42)	(1,762,012,501.89)
Дуусаагүй барилга, байгууламж	5,797,595,863.64	4,759,087,960.00		5,797,595,863.64	4,759,087,960.00
Биет бус хөрөнгө	509,925,824.00	402,088,455.07		509,925,824.00	402,088,455.07
Програм хангамж	443,624,835.18	359,350,399.62		443,624,835.18	359,350,399.62
Програм хангамж - Анхны өртөг	704,057,670.00	799,122,270.00		704,057,670.00	799,122,270.00
Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(260,432,834.82)	(439,771,870.38)		(260,432,834.82)	(439,771,870.38)
Бусад биет бус хөрөнгө	66,300,988.82	42,738,055.45		66,300,988.82	42,738,055.45
Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	107,709,472.60	107,709,472.60		107,709,472.60	107,709,472.60
Бусад биет бус хөрөнгө - Хуримтлагдсан элэгдэл	(41,408,483.78)	(64,971,417.15)		(41,408,483.78)	(64,971,417.15)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>296,585,515,764.85</b>	<b>337,502,244,112.50</b>	<b>(54,348,235,239.46)</b>	<b>296,585,515,764.85</b>	<b>283,154,008,873.04</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>154,587,847,082.04</b>	<b>125,350,790,755.19</b>		<b>154,587,847,082.04</b>	<b>125,350,790,755.19</b>
Богино хугацаат зээлийн өглөг	39,037,202,400.00	39,037,202,400.00		39,037,202,400.00	39,037,202,400.00
Гадаад валют	39,037,202,400.00	39,037,202,400.00		39,037,202,400.00	39,037,202,400.00
Олон улсын байгууллага	39,037,202,400.00	39,037,202,400.00		39,037,202,400.00	39,037,202,400.00
Төслийн зээл	39,037,202,400.00	39,037,202,400.00		39,037,202,400.00	39,037,202,400.00
<b>Өглөг</b>	<b>114,808,434,568.76</b>	<b>85,728,063,806.29</b>		<b>114,808,434,568.76</b>	<b>85,728,063,806.29</b>
Ажилчидтай холбогдсон тооцоо	7,328,590.00	7,225,422.28		7,328,590.00	7,225,422.28

Цалингийн өглөг		128,044.00		0.00	128,044.00
НДШ-ийн өглөг		3,652,949.00		0.00	3,652,949.00
ХАОАТ-ын өглөг	7,328,590.00	2,808,096.00		7,328,590.00	2,808,096.00
ҮЭ-ийн өглөг		636,333.28		0.00	636,333.28
Бараа үйлчилгээний зардлын тооцоо	2,192,063,875.40	2,528,706,985.39		2,192,063,875.40	2,528,706,985.39
Шуудан холбооны тооцоо	169,690.40	4,519.50		169,690.40	4,519.50
Бусад зардлын тооцоо	2,191,894,185.00	2,528,702,465.89		2,191,894,185.00	2,528,702,465.89
Бусад өглөг	112,609,042,103.36	83,192,131,398.62		112,609,042,103.36	83,192,131,398.62
Байгууллагад төлөх өглөг	112,603,042,103.36	83,192,116,264.62		112,603,042,103.36	83,192,116,264.62
Хувь хүмүүст төлөх өглөг	6,000,000.00	15,134.00		6,000,000.00	15,134.00
<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>742,210,113.28</b>	<b>585,524,548.90</b>		<b>742,210,113.28</b>	<b>585,524,548.90</b>
Төсөвт байгууллага	1,719,536.50	28,837,453.12		1,719,536.50	28,837,453.12
Урьдчилж орсон орлого	1,719,536.50	28,837,453.12		1,719,536.50	28,837,453.12
Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар	60,330,000.00	60,330,000.00		60,330,000.00	60,330,000.00
Бусад урьдчилж орсон орлого	680,160,576.78	496,357,095.78		680,160,576.78	496,357,095.78
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>154,587,847,082.04</b>	<b>125,350,790,755.19</b>		<b>154,587,847,082.04</b>	<b>125,350,790,755.19</b>
Засгийн газрын хувь оролцоо	141,997,668,682.81	212,151,453,357.31		141,997,668,682.81	212,151,453,357.31
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	112,474,433,615.77	112,757,179,163.80		112,474,433,615.77	112,757,179,163.80
Хуримтлагдсан үр дүн	26,632,169,532.65	96,516,088,459.03		26,632,169,532.65	96,516,088,459.03
Өмнөх үеийн үр дүн	26,632,169,532.65	24,074,025,295.39		26,632,169,532.65	24,074,025,295.39
Тайлант үеийн үр дүн		72,442,063,163.64	(54,348,235,239.46)	0.00	18,093,827,924.18
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,891,065,534.39	2,878,185,734.48		2,891,065,534.39	2,878,185,734.48
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>141,997,668,682.81</b>	<b>212,151,453,357.31</b>	<b>(54,348,235,239.46)</b>	<b>141,997,668,682.81</b>	<b>157,803,218,117.85</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>296,585,515,764.85</b>	<b>337,502,244,112.50</b>	<b>(54,348,235,239.46)</b>	<b>296,585,515,764.85</b>	<b>283,154,008,873.04</b>

**АУДИТ ХИЙГДСЭН 2013 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН  
НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ҮХААЯ-НЫ ТАЙЛАНГААР		ЗАЛРУУЛСАН	ЗАЛРУУЛСНЫ ДАРААХ	
	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ТАЙЛАНТ ОН	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>120,597,075,084.15</b>	<b>236,308,628,633.73</b>		<b>120,597,075,084.15</b>	<b>236,308,628,633.73</b>
Гадаад орнуудаас үзүүлсэн		5,474,784,787.11		0.00	5,474,784,787.11
Урсгал		4,847,924,629.99		0.00	4,847,924,629.99
Хөрөнгийн		626,860,157.12		0.00	626,860,157.12
Олон улсын байгууллагын тусламж	16,226,598,134.92			16,226,598,134.92	0.00
Урсгал тусламж	16,226,115,134.92			16,226,115,134.92	0.00
Хөрөнгийн тусламж	483,000.00			483,000.00	0.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	121,708,051,976.90	230,833,843,846.62		121,708,051,976.90	230,833,843,846.62
Улсын төвлөрсөн төсвөөс	107,574,466,695.70	211,075,555,412.57		107,574,466,695.70	211,075,555,412.57
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	75,826,360,028.10	137,536,144,564.68		75,826,360,028.10	137,536,144,564.68
Төсвийн хуваарилаагүй зардал		125,736,580.30		0.00	125,736,580.30
Хөрөнгийн	31,748,106,667.60	59,274,726,405.89	(54,860,820,946.00)	31,748,106,667.60	4,413,905,459.89
Нэмэлт санхүүжилтийн орлого		14,138,947,861.70		0.00	14,138,947,861.70
Төсвийн жилийн явцад УИХаас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллага		163,652,900.00		0.00	163,652,900.00
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс		3,891,824,798.00		0.00	3,891,824,798.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи		9,847,441,913.43		0.00	9,847,441,913.43
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		236,028,250.27		0.00	236,028,250.27
Бусад шатны (Орон нутгийн) төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	2,945,940,104.00	827,041,274.56		2,945,940,104.00	827,041,274.56
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,935,758,544.00	388,723,400.00		2,935,758,544.00	388,723,400.00
Хөрөнгийн		438,317,874.56		0.00	438,317,874.56
Засгийн газрын нөөц хөрөнгө	10,181,560.00			10,181,560.00	0.00
Төсөвт байгууллагаас	11,181,531,002.20	18,901,783,882.49		11,181,531,002.20	18,901,783,882.49
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,991,388,502.20			10,991,388,502.20	0.00
Хөрөнгийн	190,142,500.00	18,901,783,882.49		190,142,500.00	18,901,783,882.49
Нийгмийн даатгалын сангаас	6,114,175.00	29,463,277.00		6,114,175.00	29,463,277.00
НДС-ийн шилжүүлэг	6,114,175.00	29,463,277.00		6,114,175.00	29,463,277.00
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>62,605,835,199.62</b>	<b>77,463,988,014.97</b>		<b>62,605,835,199.62</b>	<b>77,463,988,014.97</b>
Өмчийн орлого	12,921,372.25			12,921,372.25	0.00
Хүүгийн орлого	12,921,372.25			12,921,372.25	0.00
Түрээсийн орлого	-			0.00	0.00
Төрийн өмч түрээслүүлсний орлого	-			0.00	0.00
Бараа, үйлчилгээний борлуулалт	62,592,913,827.37	66,604,249,440.90		62,592,913,827.37	66,604,249,440.90
Төсөвт байгууллагуудын	49,755,041,253.39	66,604,249,440.90		49,755,041,253.39	66,604,249,440.90

ажил, үйлчилгээний орлого					
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,850,176,812.97	42,495,839,357.27		3,850,176,812.97	42,495,839,357.27
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,255,416,768.47	6,222,802,412.74		2,255,416,768.47	6,222,802,412.74
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,649,447,671.95	17,885,607,670.89		43,649,447,671.95	17,885,607,670.89
Навигацийн орлого	12,837,872,573.98			12,837,872,573.98	0.00
Тусламжаас бусад шилжүүлэг		10,859,738,574.07		0.00	10,859,738,574.07
Өмч хувьчлалын орлого		10,859,738,574.07		0.00	10,859,738,574.07
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>200,540,485,311.44</b>	<b>313,772,616,648.70</b>	<b>(54,860,820,946.00)</b>	<b>200,540,485,311.44</b>	<b>258,911,795,702.70</b>
<b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>	<b>7,833,681,296.97</b>	<b>10,173,657,639.40</b>		<b>7,833,681,296.97</b>	<b>10,173,657,639.40</b>
Үндсэн болон нэмэгдэл цалин	7,050,995,050.96	9,135,968,316.71		7,050,995,050.96	9,135,968,316.71
Үндсэн цалин	4,956,234,540.44	8,026,174,131.70		4,956,234,540.44	8,026,174,131.70
Гэрээт ажилчдын цалин	1,771,901,741.11	753,381,481.01		1,771,901,741.11	753,381,481.01
Бусад нэмэгдлүүд	322,858,769.41	356,412,704.00		322,858,769.41	356,412,704.00
Унаа, болон бусад нөхөн олговор	303,087,469.41	333,118,396.00		303,087,469.41	333,118,396.00
Бусад нэмэгдэл	19,771,300.00	23,294,308.00		19,771,300.00	23,294,308.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	782,686,246.01	1,037,689,322.69		782,686,246.01	1,037,689,322.69
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	667,799,160.87	887,860,346.87		667,799,160.87	887,860,346.87
Тэтгэврийн даатгалын шимтгэл	550,510,616.94	741,907,933.32		550,510,616.94	741,907,933.32
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	27,538,759.52	56,488,940.28		27,538,759.52	56,488,940.28
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	62,666,643.45	70,986,682.33		62,666,643.45	70,986,682.33
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	27,083,140.96	18,476,790.94		27,083,140.96	18,476,790.94
Эрүүл мэндийн даатгалын хураамж	114,887,085.14	149,828,975.82		114,887,085.14	149,828,975.82
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>109,846,912,633.47</b>	<b>122,334,315,078.15</b>	<b>(512,585,706.54)</b>	<b>109,846,912,633.47</b>	<b>121,821,729,371.61</b>
Бараа үйлчилгээний урсгал зардал	29,808,346,897.11	36,557,665,430.03	(512,585,706.54)	29,808,346,897.11	36,045,079,723.49
Тогтмол зардал	679,771,182.73	857,710,830.43		679,771,182.73	857,710,830.43
Гэрэл цахилгаан	209,379,701.00	280,365,385.12		209,379,701.00	280,365,385.12
Түлш, халаалт	437,737,399.87	530,830,270.80		437,737,399.87	530,830,270.80
Цэвэр, бохир ус	32,654,081.86	46,515,174.51		32,654,081.86	46,515,174.51
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардал	12,995,948,351.46	15,165,447,688.30		12,995,948,351.46	15,165,447,688.30
Хоол		17,517,800.00		0.00	17,517,800.00
Эм, вакцин	12,995,948,351.46	15,147,929,888.30		12,995,948,351.46	15,147,929,888.30
Бусад бараа үйлчилгээний зардал	16,132,627,362.92	20,534,506,911.30		16,132,627,362.92	20,534,506,911.30
Бичиг хэргийн зардал	94,833,792.74	137,791,261.51		94,833,792.74	137,791,261.51
Тээвэр, шатахуун	552,802,847.62	830,664,366.50		552,802,847.62	830,664,366.50
Шуудан, харилцаа холбоо	96,651,053.81	139,542,982.86		96,651,053.81	139,542,982.86
Дотоод албан томилот	539,807,288.25	698,774,838.88		539,807,288.25	698,774,838.88
Гадаад албан томилот	125,032,406.80	92,444,020.80		125,032,406.80	92,444,020.80
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	3,084,099.00	20,768,791.20		3,084,099.00	20,768,791.20
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	5,658,030.00	109,965,840.00		5,658,030.00	109,965,840.00
Сургалт семинарын зардал	380,022,710.00	255,055,852.00		380,022,710.00	255,055,852.00
Эрдэм шинжилгээний ажил хийх		30,503,982.00		0.00	30,503,982.00
Жижиг эд хогшил худалдан авах	3,482,063,978.94	85,274,798.49		3,482,063,978.94	85,274,798.49
Жижиг эд хогшил худалдан авах \Багаж хэрэгсэл\	40,918,522.83	62,863,260.39		40,918,522.83	62,863,260.39
Жижиг эд хогшил худалдан авах \Тавилга\	149,800.00	13,697,640.00		149,800.00	13,697,640.00

Жижиг эд хогшил худалдан авах \Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл\	46,719,246.00	1,130,969.77		46,719,246.00	1,130,969.77
Жижиг эд хогшил худалдан авах \Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс\	3,394,276,410.11	4,847,708.33		3,394,276,410.11	4,847,708.33
Жижиг эд хогшил худалдан авах \Програм хангамж\		2,735,220.00		0.00	2,735,220.00
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	345,100,520.16	61,368,319.27		345,100,520.16	61,368,319.27
Төлбөр хураамж, жижиг татварууд	480,870,753.93	6,825,079,378.29		480,870,753.93	6,825,079,378.29
Харуул, хамгаалалтын зардал	135,475,577.11	4,284,630.00		135,475,577.11	4,284,630.00
Банкны үйлчилгээний хураамж	916,703,857.50	1,587,217.84		916,703,857.50	1,587,217.84
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,526,930,360.87	2,266,779,479.64		4,526,930,360.87	2,266,779,479.64
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	4,524,964,737.50	2,211,332,500.64		4,524,964,737.50	2,211,332,500.64
ТӨГАУ \ Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (гадаад)\		22,354,124.00		0.00	22,354,124.00
ТӨГАУ \Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж \	1,965,623.37			1,965,623.37	0.00
ТӨГАУ \Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод)\		1,180,000.00		0.00	1,180,000.00
ТӨГАУ \Эд хөрөнгийн даатгал\		2,084,119.00		0.00	2,084,119.00
ТӨГАУ \Тээврийн хэрэгслийн даатгал\		27,780,676.00		0.00	27,780,676.00
ТӨГАУ \Тээврийн хэрэгслийн оношилгоо\		2,048,060.00		0.00	2,048,060.00
Маягт хэвлүүлэх зардал	6,291,500.00	18,023,500.00		6,291,500.00	18,023,500.00
Урсгал засвар	390,124,822.29	363,156,775.38		390,124,822.29	363,156,775.38
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал		6,900,000.00		0.00	6,900,000.00
Гадаадын зочны зардал	7,642,649.00	10,504,434.00		7,642,649.00	10,504,434.00
Бусад зардал	433,678,933.80	2,913,516,779.29		433,678,933.80	2,913,516,779.29
Засварын зардал		2,796,290.00		0.00	2,796,290.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	3,226,436,357.54	4,320,186,194.43	(512,585,706.54)	3,226,436,357.54	3,807,600,487.89
Аж ахуйн материал худалдан авах зардал	333,779,570.16	1,206,962,420.85		333,779,570.16	1,206,962,420.85
Бараа материал акталсны зардал	10,413,739.40	77,528,783.07		10,413,739.40	77,528,783.07
Газрын төлбөр	1,917,064.00	1,251,975.00		1,917,064.00	1,251,975.00
Товхимол, тараах материал	37,305,450.00	53,794,000.00		37,305,450.00	53,794,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	80,038,565,736.36	85,776,649,648.12		80,038,565,736.36	85,776,649,648.12
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	79,954,866,825.36	84,290,194,977.39		79,954,866,825.36	84,290,194,977.39
Мал аж ахуйн үржлийн зардал	160,636,826.00	1,483,661,900.02		160,636,826.00	1,483,661,900.02
Мал эмнэлгийн үйлчилгээний зардал	9,703,619,916.43	15,875,246,173.16		9,703,619,916.43	15,875,246,173.16
Ногоон хувьсгалын зардал	10,887,997.10	506,874,911.14		10,887,997.10	506,874,911.14
